



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 11 сарын 24 өдөр

Дугаар 579

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Гадаадын иргэн, харьяатын газрын Дорноговь аймаг дахь газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 20,000,000.00 (хорин сая) төгрөгийн балансын үнэ, 16,111,111.24 (арван зургаан сая нэг зуун арван нэгэн мянга нэг зуун арван нэгэн төгрөг хорин дөрвөн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан тээврийн хэрэгслийг Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь Сум дундын прокурорын газрын Сум дундын ерөнхий прокурор, хууль цаазын итгэмжит зөвлөх Д.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашины улсын дугаарыг бүртгэлээс шилжүүлсэн тодорхойлолт, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 282 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны дүгээр сарын ний едрийн
 57 дугаар тогтоолын хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
 БҮРТГЭЛТЭЙ, ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАМЫН-ҮҮД СУМ ДАХЬ СУМ ДУНДЫН ПРОКУРОРЫН
 ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ

Д/д	Автомашинны нэр, улсын бүртгэл, арлын, хөдөлгүүрийн дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Хьюндай старекс, 45-90 ДГА (арал-кмјwwһ7һр6и699888)	2006	168795	20,000,000.00	16,111,111.24	3,888,888.76
Нийт дүн					16,111,111.24	3,888,888.76
				20,000,000.00 (хорин сая)	(арван зургаан сая нэг зуун арван нэгэн мянга нэг зуун арван нэгэн төгрөг хорин дөрвөн мөнгө)	3,888,888.76 (гурван сая найман зуун наян найман мянга найман зуун наян найман төгрөг далан зургаан мөнгө)